



МОНГОЛ УЛС  
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 03 сарын 10 өдөр

Дугаар A/27

Номгон

Г

Г

“Суралцагч аймаг-2025” төсөлт үйл ажиллагааг зохион байгуулах ажлын хэсэг томилж, удирдамж, ажлын төлөвлөгөө батлах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2023 оны 12 дугаар сарын 04 -ны өдрийн “Насан туршийн суралцахуйн төвийн үйл ажиллагааны журам батлах тухай” А/535 дугаар тушаалын 2 дугаар зүйлийн 2.1.7, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2024 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн “Аймгийн 2025 оны хөгжлийн төлөвлөгөө батлах тухай” 4/27 дугаар тогтоолыг дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Суралцагч аймаг-2025” төсөлт үйл ажиллааг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Суралцагч аймаг 2025” төсөлт, үйл ажиллагааны удирдамжийг хоёрдугаар хавсралтаар, хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гуравдугаар хавсралтаар, санхүүгийн зарцуулалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2.“Суралцагч аймаг” төсөлт үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд шаардагдах 10.000.000 (Арван сая) төгрөгийг Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д зөвшөөрсүгэй.


3.“Суралцагч аймаг 2025” төсөлт үйл ажиллагааны хүрээнд орон нутагт “Суралцагч сум төсөлт үйл ажиллааг хэрэгжүүлэх ажлын хэсэг байгуулж, удирдамж, төлөвлөгөөг батлан үр дүнтэй зохион байгуулж, тайланг хагас бүтэн жилээр ирүүлэхийг Засаг дарга нарт, үйл ажиллагааны нэгдсэн тайланг 2025 оны 12 дугаар сард багтаан аймгийн Засаг даргын Тамгын газрын Удирдлагын багт танилцуулахыг Насан туршийн суралцахуйн төвийн захирал (Д.Амгалан)-д үүрэг болгосугай.

625010430


W:\2025 ON\ZAKHIRAMJ\ZAKHIRAMJ++.DOCX1

4.“Суралцагч сум” төсөлт үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг орон нутаг хөгжүүлэх сан, байгууллагын зардал, төсөл хөтөлбөр, иргэд, аж ахуйн нэгжийн хандив тусlamжийн хүрээнд шийдвэрлэхийг байгууллагын удирдлагууд, сумын Засаг дарга нарт зөвлөсүгэй.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Б.Наранбаярт)-т даалгасугай.



625010104



Digitized by srujanika@gmail.com

ପାଇଁ କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା କିମ୍ବା

book  $\frac{1}{5}$  Oct  $\frac{1}{11}$  40  $\frac{1}{10}$

Digitized by srujanika@gmail.com

१८४



Digitized by srujanika@gmail.com

Digitized by srujanika@gmail.com

Аймгийн Засаг даргын 10-ны 1-дугаар  
сарын 10-ны өдрийн 1-дугаар захирамжийн  
..... дүгээр хавералт



**“СУРАЛЦАГЧ АЙМАГ” ТӨСӨЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН**

Ажлын хэсгийн ахлагч:

Аймгийн Засаг даргын Зөвлөх

Гишүүд:

Нийгмийн бодлогын хэлтсийн дарга

Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Нийгмийн бодлогын хэлтсийн боловсрол хариуцсан мэргэжилтэн

Эрүүл мэндийн газрын дарга

Боловсролын газрын дарга

Онцгой байдлын газрын дарга

Байгаль орчны газрын дарга

Нийгмийн даатгалын газрын дарга

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга

Биеийн тамир, спортын газрын дарга

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын дарга

Стандарт хэмжил зүйн хэлтсийн дарга

Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргааны дарга

Бөөн цагаан орог нуурын сав газрын захиргааны дарга

Монголын нотариатчидын танхимын Баянхонгор аймаг дахь салбарын дарга

Нарийн бичгийн дарга:

Насан туршийн суралцахуйн төвийн захирал.

-----оо-----

Аймгийн Засандарын ... оны ... дугаар  
сарын ... -ны өдрийн ... дугаар захирамжийн  
... дугаар хавсралт

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ХЭМЖЭЭНД ЗОХИОН БАЙГУУЛАХ  
“СУРАЛЦАГЧ АЙМАГ-2025” ТӨСӨЛТ АЖЛЫН  
ТУХАЙ УДИРДАМЖ**

**Нэг. Хэрэгцээ шаардлага**

Боловсролын талаарх дэлхий нийтээр баримтлах чиг хандлага өөрчлөгдөн насан туршдаа суралцахуй буюу тасралтгүй суралцах зарчмыг чухалчилж байгаа бөгөөд боловсрол эзэмших арга замыг заавал хичээллээр, анги танхимд олгодог, боловсролын үйлчилгээний гол цөм нь хүүхэд хэмээн үзсээр ирсэн ойлголт өөрчлөгдөн, зах зээлийн нийгэм, мэдээллийн эрин үед амьдарч буй бүх иргэдийн хэрэгцээнд тохирсон сургалтын шинэ хэлбэрүүд бий болж, насан туршийн боловсролын үзэл баримтлал дэлгэрсэн.

Иргэний боловсрол, ухамсын түвшин хангалтгүй, өөрсдийн үүргээ мэдэхгүй, эрхээ хэт дээдэлсэн, бусдын эрх ашгийг хүндэтгэх, олон нийтийн арга хэмжээнд оролцох идэвх оролцоо хангалтгүй, өөрсдийн дуу хоолой, санал бодлоо бодлого төлөвлөлтөд тусгах, төрөөс хийгдэж байгаа аливаа үйл ажиллагаанд оролцох, хяналт тавих сэтгэлгээ байхгүй, байгаль экологийн хайрлах, хамгаалах, харилцааны соёл, үгийн баялаггүй болсон.

Монгол Улсын иргэн нь: Үндсэн хууль, бусад хуулийг дээдлэн хүндэтгэж, сахин биелүүлэх; хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, хуулиар ногдуулсан албан татвар төлөх, эх орноо хамгаалах, хуулийн дагуу цэргийн алба хаах гэсэн үндсэн үүрэг, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэгтэй боловч хуулиа дээдэлж эрүүл мэндээ хамгаалах, хуулийн хүрээнд амьдралын чанараа нэмэгдүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх мэдлэг, ойлголт дутмаг байна.

Иймд мэдээлэл технологийн хурдацтай хөгжлийн эрин үетэй хөл нийлүүлэн хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах, үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлэх, байгаль орчноо хамгаалахад тасралтгүй суралцах арга барилыг иргэдэд төлөвшүүлж суулгах нь нэн чухал байна.

**Хоёр. Зорилго:**

Тасралтгүй суралцах нь ажил, амьдралдаа амжилттай байх, орон нутгийн болон улсын хөгжлийн гол хөдөлгөгч хүч болох үр хүүхдэдээ гэрэл, гэгээтэй ирээдүйг үлдээх ач холбогдолтойг ухааруулсан насан туршдаа суралцагч иргэн бүхий “Суралцагч аймаг”, “Суралцагч сум” болоход оршино.

**Гурав. Зорилт:**

3.1. Бүх сумдад “Суралцагч сум” төсөлт ажлыг “Суралцагч байгууллага”, “Суралцагч гэр бүл”, “Суралцагч иргэн”, “Суралцагч хүүхэд” үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлэх

3.2. Төрийн албан хаагчид, гэр бүл, иргэн, хүүхдэд үндэсний өв соёл, нийгмийн харилцааны соёл, хууль, дүрэм журмын мэдлэг ойлголтоо тасралтгүй дээшлүүлж, эрүүл зөв амьдралын хэвшилтэйгээр эрүүл аюулгүй орчныг бурдуулж чанартай сурх, ажиллах, амьдрах суралцахуйн арга барилыг эзэмшихэд дэмжлэг үзүүлэх

**Дөрөв. Хүлээгдэж буй үр дүн:**

**Аймгийн хэмжээнд:**

4.1. “Суралцагч байгууллага” үйл ажиллагаанд 80-аас багагүй байгууллага, 3500-аас багагүй албан хаагч хамрагдаж, хамтдаа суралцах бөгөөд 6000-аас багагүй иргэнд соён гэгээрүүлэх сургалт нөлөөллийн ажлыг хүргэж, амьдралын чанарт нь дэмжлэг үзүүлсэн байна.

4.2 “Суралцагч гэр бүл” үйл ажиллагаанд 250 гэр бүлийг хамруулж, хамтдаа суралцах бөгөөд зорилтот бүлгийн 500 гэр бүлд зөв дадал төлөвшүүлэх, цахим орчинд 3000-аас багагүй иргэнд нөлөөллийн үйл ажиллагааг явуулж, суралцахуйдuriалсан байна.

4.3 “Суралцагч хүүхэд” үйл ажиллагаанд ерөнхий боловсролын сургуулийн 85-аас багагүй ангийн 2500 орчим хүүхдийг хамруулж, зөв хүүхэд байх сургалт, нөлөөллийн үйл ажиллагаагаар чадваржуулж, хүүхдээс хүүхдэд аргачлалаар сургуулийн нийт хүүхдийн 30%-д нь сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг явуулж, ирээдүйг авч явах хүүхдүүдэд суралцах арга барилыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.

4.4. “Суралцагч иргэн” үйл ажиллагаанд 1500-аас багагүй иргэнийг хамруулж, 5000 -аас багагүй иргэнд эрүүл зөв дадал хэвшилтэй, хүүхдүүдээ зөв үлгэр дуурайлал үзүүлэх, амьдрах ухаан хийгээд хувийн манлайллын чадвартай, амьдралын чанараа дээшлүүлэх ухамсарт зан үйлтэй, ёс суртахууны өндөр чадамжтай, байгальдаа ухамсартайгаар ханддаг, хуулийн хэрэгжилтийг мөрддөг, өрхийн санхүү болон хувийн санхүүгээ зөв удирдан

чиглүүлэх дадлуудыг хэвшүүлдэг, хөгжлийг эрхэмлэгч иргэнийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

- Аймгийн хэмжээнд чиглэл бүрийн дагуу нийт хүн амын 30-аас доошгүй хувьд хүрч үйлчилнэ.

#### **Сумын хэмжээнд:**

**6.3. “Суралцагч байгууллага”** үйл ажиллагаанд 5-аас багагүй байгууллага, 75-аас багагүй албан хаагч хамрагдаж, хамтдаа суралцаж, амьдралын чанарт нь дэмжлэг үзүүлсэн байна.

**6.4. “Суралцагч гэр бүл”** үйл ажиллагаанд 3-5 настай цэцэрлэгт хамрагддаг хүүхэдтэй 20-35 насны 10-аас багагүй гэр бүл хамрагдаж, хамтдаа суралцах бөгөөд зорилтот бүлгийн 40 гэр бүлд зөв дадал төлөвшүүлэх, цахим орчинд 500-аас багагүй иргэнд нөлөөллийн үйл ажиллагааг явуулж, суралцахуйд уриалсан байна.

**6.5. “Суралцагч хүүхэд”** үйл ажиллагааны хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 4-өөс багагүй анги, бүлгийн 100-аас дээш хүүхдэд сургалт, нөлөөллийн үйл ажиллагаагаар чадваржуулах бөгөөд хүүхдээс хүүхдэд аргачлалаар тухайн сургуулийн нийт хүүхдийн 30%-д нь сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулж, ирээдүйг авч явах хүүхдүүдэд суралцах арга барилыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна.

**6.6. “Суралцагч иргэн”** үйл ажиллагаанд сум тус бүр 100-аас багагүй иргэнийг сонгон жилийн турш үйл ажиллагаанд хамруулна.

Цэцэрлэгийн хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчдын 50%, ЕБС-ийн сурагчдын эцэг эх, асран хамгаалагчдын 40%-г сургалтад хамруулна. Эрүүл зөв дадал хэвшилтэй, хүүхдүүдээ зөв үлгэр дуурайлал үзүүлэх, амьдрах ухаан хийгээд хувийн манлайллын чадвартай, амьдралын чанараа дээшлүүлэх ухамсарт зан үйлтэй, ёс суртахууны өндөр чадамжтай, байгаль эх дэлхийдээ ухамсартайгаар ханддаг, хуулийн хэрэгжилтийг мөрддөг, өрхийн санхүү болон хувийн санхүүгээ зөв удирдан чиглүүлэх дадлуудыг хэвшүүлдэг, хөгжлийг эрхэмлэгч иргэнийг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

**6.7.** Чиглэл бүрийн дагуу сумын хэмжээнд нийт хүн амын 30-иас багагүй хувьд хүрч үйлчилнэ.

#### **Тав. Хэрэгжүүлэх хугацаа:**

**5.1.”Суралцагч аймаг”** төсөлт ажлыг 2025-2028 онд хэрэгжүүлнэ.

**Зургаа. Хэрэгжүүлэх арга зам:**

**6.1.“Суралцагч аймаг” төсөлт ажлын нэгдсэн удирдамж, хөтөлбөрийг аймгийн Засаг даргын Тамгын газар, Баянхонгор аймгийн Насан туршийн суралцахуйн төвөөс гаргаж, “Суралцагч сум” төсөлт ажлыг нэгдсэн удирдлага, чиглэлээр хангаж ажиллана. Сумдууд “Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Сумын 2025 оны хөгжлийн төлөвлөгөө”-д зорилт болгон оруулж, хэрэгжүүлэх санхүүжилтийг шийдвэрлэнэ.**

#### **Долоо. Зохион байгуулах байгууллага**

**7.1. Аймагт: Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар, Баянхонгор аймгийн Насан туршийн суралцахуйн төв хариуцна.**

Сумдад: Сумын Засаг даргын Тамгын газар, Ерөнхий боловсролын сургууль, Насан туршийн суралцахуйн нэгж, Сургуулийн өмнөх боловсролын байгууллага, Соёлын төв, Эрүүл мэндийн төв, бусад байгууллага, хувь хүнээс бүрдсэн хэрэгжүүлэгч баг хариуцан зохион байгуулна.

**7.2. Мэргэжлийн хувьд зөвлөх, дэмжих, чиглүүлэх байгууллага:** Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтэс, агентлаг, газар, хэлтсүүд /Боловсролын газар, Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, Байгаль орчны газар, Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын газар, Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Биеийн тамир спортын газар, Хүнс, Хөдөө аж ахуйн газар, Монголын нотариатчдын танхимын Баянхонгор аймаг дахь салбар, , аймгийн Хэлний бодлогын салбар зөвлөл, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Бөөн цагаан орог нуурын сав газрын захиргаа/

**Найм “Суралцагч сум” төсөлт ажлыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:**

**8.1. “Суралцагч байгууллага” арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

- Хуулиа дээдлэгч
- Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэгч
- Эрүүл мэнд, эрүүл харилцааг эрхэмлэгч
- Өв соёлоо эрхэмлэгч

**8.2. “Суралцагч гэр бүл” арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

- Хуулиа дээдлэгч
- Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэгч
- Эрүүл мэнд, эрүүл харилцааг эрхэмлэгч
- Өв соёлоо эрхэмлэгч

**8.3. “Суралцагч иргэн” арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

- Хуулиа дээдлэгч
- Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэгч
- Эрүүл мэнд, эрүүл харилцааг эрхэмлэгч
- Өв соёлоо эрхэмлэгч

**8.4. “Суралцагч хүүхэд” арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл**

- Хуулиа дээдлэгч
- Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэгч

- Эрүүл мэнд, эрүүл харилцааг эрхэмлэгч
- Өв соёлоо эрхэмлэгч

#### **Ес. Зохион байгуулалт:**

9.1. “Суралцагч сүм” төсөлт ажлын хэрэгжүүлэгч багийг мэдээллээр хангах, чадваржуулах сургалтыг 2025 оны 3 сард зохион байгуулна.

9.3. “Суралцагч сүм” төсөлт ажилд оролцогч “Суралцагч байгууллага”, “Суралцагч гэр бүл”, “Суралцагч иргэн”, “Суралцагч хүүхэд” арга хэмжээнд хамрагдах бүртгэлийг 2025 оны 3 дугаар сард хийнэ.

9.4. Сум бүр “Суралцагч сүм” төсөлт ажлын хүрээнд” Суралцагч байгууллага, Суралцагч гэр бүл, Суралцагч иргэн, Суралцагч хүүхэд” арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 4 дүгээр сарын 10-ны дотор гаргаж ирүүлнэ.

9.5. “Суралцагч сүм” төсөлт ажлын явцын үнэлгээг 2 удаа зохион байгуулна. Хэрэгжилтийн тайланг хагас болон бүтэн жилээр авч дүгнэнэ.

9.6. “Суралцагч аймаг” төсөлт ажлын хаалтын үйл ажиллагааг 2025 оны 11 сард зохион байгуулна.

#### **Арав. “Суралцагч аймаг” төсөлт ажлыг үнэлэх:**

##### **10.1 “Суралцагч сүм”-ын шалгуур үзүүлэлт:**

- ✓ Суралцагч байгууллага, Суралцагч иргэн, Суралцагч хүүхэд, Суралцагч гэр бүлийн шалгуур үзүүлэлт тус бүрийг хангасан байх
- ✓ “Суралцахуйг дэмжигч сүм” баярын арга хэмжээг зохион байгуулан нийт хүн амын 10-аас багагүй хувийг хамруулсан байх
- ✓ Сумын нийт хүн амын 30-иас доошгүй хувийг хамруулсан байх
- ✓ СӨБ-ын 50%-иас багагүй хувь, ЕБС-ын 40-өөс багагүй хувийн нийт эцэг эх, асран хамгаалагч харгалзан дэмжиг ч нарт сургалт, үйл ажиллагааг зохион байгуулсан байх
- ✓ Өв соёлоо эрхэмлэгч зорилтын хүрээнд сүм орон нутгийнхаа онцлог, чадамжид тулгуурлан 1-ээс доошгүй ажлыг санаачлан хэрэгжүүлсэн байх
- ✓ Сургалт, үйл ажиллагааны зорилтот тоонд хүрсэн байх
- ✓ Тайлан, мэдээг товлосон хугацаанд илгээсэн байх
- ✓ Явцын үнэлгээ
- ✓ Нэгдсэн уралдаан, тэмцээний үнэлгээ
- ✓ Иргэдийн боловсролын суурь түвшний судалгааг гаргах, иргэдийн боловсролыг дээшлүүлэхэд үзүүлсэн бодит дэмжлэг, санхүүжилтийн хэмжээ

##### **10.2.1 “Хуулиа дээдлэгч сүм”-ын шалгаруулах шалгуур үзүүлэлт**

- ✓ Хуулиа дээдлэгч байгууллага, гэр бүл, иргэн, хүүхдийн шалгуур үзүүлэлт буюу үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлсэн байх
- ✓ Байгууллага тусгагдсан 6 хууль, гэр бүл, иргэн тусгагдсан 4 хууль, суралцагчид “Үе тэнгийн дээрэлхэлт”-ийг бууруулах, сургалтад хамрагдсан байх
- ✓ Төлөвлөгөөнд тусгагдсан ажлын нөлөөллийн ажлыг зохион байгуулсан байх

- ✓ “Хуулиа дээдлэгч сүм” удирдамжид уралдааны 1,2-р шатны дүн
- ✓ Төлөвлөсөн үйл ажиллагаанд нийт оролцогчдын 95-аас доошгүй хувийг хамруулсан байх
- ✓ Ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээний үр дүн, чанар

#### **10.3 “Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэгч сүм”-ын шалгаруулах шалгуур үзүүлэлт**

- ✓ Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэгч байгууллага, гэр бүл, иргэн, хүүхдийн шалгуур үзүүлэлт буюу үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлсэн байх
- ✓ Галын аюулгүй байдлын тухай, “Хог хаягдлыг ангилан ялгах, хуванцар сав, лаазыг дахин боловсруулах цэгт тээвэрлэж нийлүүлэх, усны эх ундаргыг хамгаалах, аймгийн тусгай хамгаалалттай газрын тухай, хамгаалахын ач тус, Мод тарих аргачлал, ач холбогдол” сургалтад сумын байгууллага, албан хаагчид, гэр бүл, иргэн, анги хамт олон хамрагдсан байх
- ✓ Эх дэлхийдээ ээлтэй сүм удирдамжид уралдааны дүн
- ✓ Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэх хүрээнд санаачлан зохион байгуулсан бүтээлч ажлын үр дүн, зарцуулагдсан төсөв
- ✓ Ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээний үр дүн, чанар

#### **10.4 “Эрүүл мэнд, эрүүл харилцааг эрхэмлэгч сүм”-ын шалгаруулах шалгуур үзүүлэлт**

- ✓ Эрүүл мэнд, эрүүл харилцааг эрхэмлэгч байгууллага, гэр бүл, иргэн, хүүхдийн шалгуур үзүүлэлт буюу үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлсэн байх
- ✓ “Эрүүл мэндээ хамгаалья” багц сургалтад нийт оролцогчдын 95-аас доошгүй хувийг хамруулсан байх
- ✓ Эрүүл, зерэг дадлыг хэвшүүлэх бүтээлч ажил, арга хэмжээг санаачлан зохион байгуулж нийт хүн амын 20-иос доошгүй хувийг хамруулсан байх
- ✓ Удирдамжит уралдааны дүн
- ✓ “Цэнгээнт бүжиг”, ажлын байрны дасгал хөдөлгөөнийг бүх нийтийн соёл болгон хэвшүүлсэн байх. Нийт оролцогчдын 60-аас багагүй хувийг, нийт хүн амын 5-аас багагүй хувийг хамруулсан байх
- ✓ “Эрүүл иргэн- Зөв монгол” агуулгын хүрээнд зохион байгуулсан үйл ажиллагаа, нөлөөллийн ажлын тоо, нийт хүм амын хамрагдалтын хувь
- ✓ Өрхийн төсвийн дэвтэр хөтөлж хэвшсэн иргэдийн эзлэх хувь
- ✓ Ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээний үр дүн, чанар

#### **10.5. “Өв соёлоо эрхэмлэгч сүм”-ын шалгаруулах шалгуур үзүүлэлт**

- ✓ Өв соёлоо эрхэмлэгч байгууллага, гэр бүл, иргэн, хүүхдийн шалгуур үзүүлэлт буюу үйл ажиллагаа тус бүрийг хэрэгжүүлсэн байх
- ✓ Сумын хэмжээнд 1-ээс доошгүй ажлыг санаачлан хэрэгжүүлэн нийт хүн амын 30-аас доошгүй хувийг хамруулсан байх
- ✓ Нөлөөллийн үйл ажиллагаа
- ✓ “Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-ийн удирдамжит ажлын дүн
- ✓ “Соёлын биет бус өвийг дэлгэрүүлэгч” удирдамжит уралдааны дүн

- ✓ Төлөвлөгөөт үйл ажиллагаанд нийт оролцогчдын 95-аас доошгүй хувийг хамруулсан байх
- ✓ Ажлын төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан мэдээний үр дүн, чанар  
**Арван нэг. Шагнал, урамшуулал:**

**11.1.** Сум бүр “Шилдэг Суралцагч байгууллага”, “Шилдэг Суралцагч гэр бүл”, “Шилдэг Суралцагч иргэн”, “Шилдэг Суралцагч хүүхэд”-г тус бүр шалгаруулж, урамшуулах зардлаа хариуцна.

**11.2.** Аймгийн хэмжээнд “Шилдэг Суралцагч сум”-3, “Хуулиа дээдлэгч сум”-3, “Эрүүл, аюулгүй орчин бүрдүүлэгч сум”-3, “Эрүүл мэнд, эрүүл харилцааг эрхэмлэгч сум”-3, “Өв соёлоо эрхэмлэгч сум”-3 байрыг тус тус шалгаруулна.

**11.3.** “Шилдэг Суралцагч сум”-ын шагналын сан 9.000.000

1-р байр өргөмжлөл 4.000.000 төгрөг

2-р байр өргөмжлөл 3.000.000 төгрөг

3-р байр өргөмжлөл 2.000.000 төгрөг

**Холбоо барих утас:** Баянхонгор аймгийн Насан туршийн суралцахуйн төвийн захирал Д. Амгалан


Утасны дугаар: 88318822

Сургалтын менежер: Т. Батжаргал

Утасны дугаар : 80029920

-----oOo-----

Аймгийн Засаг даржин 2025 оны 03 дугаар  
сарын 10-ны өдрийн 10 дугаар зурагчрамжийн  
дугаар хавсролт



**“СУРАЛЦАГЧ АЙМАГ” ТӨСӨЛТ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
2025 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

**Зорилго:** Тасралтгүй суралцах нь ажил, амьдралдаа амжилттай байх, орон нутгийн болон улсын хөгжлийн гол хөдөлгөгч хүч болох, үр хүүхдэдээ гэрэл, гэгээтэй ирээдүйг үлдээх ач холбогдолтойг ухааруулсан насан туршдаа суралцагч иргэн бүхий “Суралцагч аймаг” болоход оршино.

**Зорилт:** Төрийн албан хаагчид, гэр бүл, иргэн, хүүхдэд үндэсний өв соёл, нийгмийн харилцааны соёл, хууль, дүрэм журмын мэдлэг ойлголтоо тасралтгүй дээшлүүлж, эрүүл зөв амьдралын хэвшилтэйгээр эрүүл аюулгүй орчныг бүрдүүлж чанартай сурх, ажиллах, амьдрах суралцахуйн арга барилыг эзэмшихэд дэмжлэг үзүүлэх

**Хамрах хүрээ:** Баянхонгор аймгийн 20 сумын төрийн байгууллагууд, ЕБС-ын суралцагчид, эцэг эх, асран хамгаалагч, гэр бүл, иргэд хамрагдана.

2025 оны 03 дугаар сарын 06

Номгон

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Хүрэх үр дүнгийн шалгуур	Хугацаа	Хариуцах нэгж	Хамтран хэрэгжүүлэх байгууллага
1	2	3	4	5	6	7	8
1	Сургагч багш бэлтгэх, чадавхжуулах сургалтыг зохион байгуулах	Зохион байгуулагч талууд	Чадавхажсан албан хаагчдын тоо	Сумдын 150-аас багагүй оролцогчдыг чадваржуулсан байна.	02-03 сард	АЗДТГ, НТСТ	Аймгийн ЗДТГ-ын ХЭХ, БХР аймаг дахь Нотариатчдын салбар, Боловсролын газар, ХХҮГ, ЭМГ

1	2	3	4	5	6	7	8
<b>Зорилт 1. "Хуулиа дээдлэгч сүм" зорилтын хүрээнд</b>							
2	1.1.Иргэдэд хэрэгцээт хууль, тогтоомжийн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулах	Тухайн сүм, байгууллага	-Хуулийн тоо -Хууль судалсан албан хаагчийн тоо -Сургалт, нөлөөллийн ажилд хамрагдсан иргэдийн тоо	a. Байгууллага бүр хавсралтад тусгасан б хуулийг албан хаагчдаар судлуулсан байна. Нийт 3500 албан хаагчид хамрагдана. б. Байгууллага бүр өөрийн чиг үүрэгт хамаарах хууль, тогтоомжийн сургалтад 80-аас доошгүй иргэдийг хамруулна. Нийт 5000-н иргэд хамрагдана.	04-10 сар	Суралцаач байгууллага	Сумдын ЗДТГ, БХР аймаг дахь Нотариатчдын салбар,
3		Тухайн сүм, сургууль	-Сургалтад хамрагдсан сургач, эцэг эх, асран хамгаалагчийн тоо -Нөлөөллийн ажлын тоо -Нөлөөллийн ажилд хамрагдсан тухайн сургуулийн нийт сургачдын хамрагдалтын хувь	a. Ye тэнгийн дээрэлхэлтгүй зэрэг харилцаа сургалтад 2500-аас доошгүй сургачид 1500-аас доошгүй эцэг эх, асран хамгаалагч нарыг хамруулна. б. Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтад 8,10 дугаар ангийн 1400 суралцаачид хамрагдана. -Мэргэжил сонголтын үеийн сэтгэл зүй -Өөрийгөө таних ойлгох -Мэргэжлээ зөв сонгох сэдвээс сонгон сургалтыг зохион байгуулсан байна. в. Анги бүр 2-оос доошгүй нөлөөллийн ажлыг АМЧБО чиглэлээр зохион байгуулж сургуулийнхаа 30-аас доошгүй хувийг хамруулна.	04-11 сар	Суралцаач хүүхэд	Ерөнхий боловсролын сургуулиуд
4		Тухайн сүм, байгууллага, гэр бүл, иргэн	-Хуулийн сургалтад хамрагдсан иргэн, гэр бүлийн тоо -Нөлөөллийн ажлын тоо, хамрагдсан иргэдийн тоо	a. Хавсралтад тусгасан хуулийн хүрээнд 1800 иргэн, 250 гэр бүл хамрагдана. б. Судалсан хуулийн агуулгын хүрээнд 1-ээс доошгүй нөлөөллийн ажлыг зохион байгуулж 2500 иргэн, гэр бүлийг хамруулна.	04-06 сар	Суралцаач гэр бүл, суралцаач иргэн	АЗДТГ-ын НБХ, ХЗХ, сумдын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8
5			-Түгээсэн цахим постер, шторкийн тоо	а Байгууллага тус бүр өөрсдийн хууль, тогтоомжийн хүрээнд 5-аас доошгүй постер, 2-оос доошгүй шторк боловсруулан түгээсэн байна.	04-11 сар	Суралцагч байгууллага	АЗДТГ-ын НБХ, ХЗХ, сумдын ЗДТГ
6	1.2. "Хуулиа дээдэлье" удирдамжид уралдаан зохион байгуулах	Тухайн сум	- Зохион байгуулсан хэлэлцүүлгийн тоо -Ирүүлсэн тайлангийн давтамж -Оролцсон албан хаагчдын тоо	a.1.1 дэх ажлыг хэрэгжүүлсэн байгууллага, албан хаагчдын дунд "Хуулиа дээдэлье" 1-р шатны уралдааныг хэрэгжүүлэгч баг зохион байгуулах ба байгууллагууд удирдамжийн дагуу албан хаагчдаа хамруулна. -Уралдааны удирдамжийн чиглэл, тайлангийн загвар хүргэгдэнэ. Тайланг хугацаандаа ируулнэ.	06 сар	Суралцагч байгууллага	АЗДТГ-ын ХЗХ, БХР аймаг дахь Нотариатчидын салбар, НТСТ, сумдын хэрэгжүүлэгч баг
7		Тухайн байгууллага	- Оролцсон албан хаагчдын тоо	а. 1-р шатны уралдаанд тэргүүн байр эзэлсэн 20 сумын байгууллагын 60-аас доошгүй албан хаагчдын дунд 2-р шатны мэтгэлцээний уралдааныг аймгийн төвд зохион байгуулна. - Уралдааны удирдамж чиглэл хүргэгдэнэ.	10 сар	Суралцагч байгууллага	АЗДТГ-ын ХЗХ, БХР аймаг дахь Нотариатчидын салбар, НТСТ
<b>Зорилт 2. "Эрүүл аюулгүй, орчин бүрдүүлэгч сум" зорилтын хүрээнд</b>							
8	2.1. "Эрүүл, зэлтэй орчинтой сум" сургалт, бүтээлч ажил зохион байгуулах	Тухайн байгууллага	-Хос бичгээр гаргасан гудамж, байрын хаягийн тоо - Стандарт хангасан ариун цэврийн байгууламжтай байгууллага, гэр бүл, иргэний тоо -Зөвлөмжийг хүргэн ажилласнаар	а. 300-аас доошгүй гудамж, байрын хаягжилтиг хос бичгээр хийсэн байна. б. 20-иос доошгүй байгууллага эрүүл ахуйн стандарт хангасан ариун цэврийн байгууламжаар үйлчлэх боломжийг үлгэр жишээ бүрдүүлсэн байх; б. 50-иас доошгүй иргэн, гэр бүлүүд шаардлага хангасан нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болсон байна.	04-11 сар	Суралцагч байгууллага, гэр бүл, иргэн	Стандарт хэмжил зүйн хэлтэс, ЭМГ, Боловсролын газар

1	2	3	4	5	6	7	8
9	2.2. “Эрсдэлгүй сум” сургалт зохион байгуулах	Тухайн сум, байгууллага	-Сургалтад хамрагдсан байгууллагын тоо -Хамрагдсан албан хаагчид, гэр бүл, иргэн, сурагчдын тоо -Гал унтраах багажийг бүрдүүлсэн байгууллагын тоо	а. Галын аюулгүй байдлын тухай сургалтад 80-аас доошгүй байгууллагын 3000-н албан хаагчид, 250 гэр бүл, 1200 иргэн, 2500 суралцагчид хамрагдана. б. Нийт байгууллагын 80-аас доошгүй хувь нь галын аюулгүй байдлын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалт, Аж ахуйн нэгж, байгууллагын, барилга байгууламжид зайлшгүй байх гал унтраах багаж хэрэгслийн шаардлага, норм MNS 5566:2020-ын 4.1, 4.7, 5 дахь заалтыг хангаж анхан шатны багаж хэрэгслийг бүрдүүлсэн байна. - Зөвлөмж, чиглэл хүргэгдэнэ.	04-11 сар	Суралцагч байгууллага, гэр бүл, иргэн, хүүхэд	Сумдын ЗДТГ, хэрэгжүүлэгч баг, ОБГ
10	2.3. Эх дэлхийдээ ээлтэй сум	Тухайн сум, байгууллага	- Сургалтад хамрагдсан албан хаагч, иргэд, гэр бүлийн тоо - Бүтээлч ажлын тоо -Тайлангийн чанар, хугацаа	- “Хог хаягдлыг ангилан ялгах, хуванцар сав, лаазыг дахин боловсруулах цэгт тээвэрлэж нийлүүлэх, аймгийн дархан цаазат газрын тухай, хамгаалахын ач тус, усны эх ундаргыг хамгаалах, Мод тарих аргачлал, ач холбогдол” зэрэг сургалтад 3000-н албан хаагч, 250 гэр бүл, 1200 иргэн, 2500 суралцагчид хамрагдана. - Сум тус сургалтын агуулгын хүрээнд олон төрөлт бүтээлч ажлыг санаачлан, 1-ээс доошгүй удаа зохион байгуулна. - Бүтээлч ажлын удирдамж, чиглэл хүргэгдэнэ. Тайланг товлосон хугацаанд зураг, тайлбартай ирүүлнэ.	4-10 сар	Суралцагч байгууллага, гэр бүл, иргэн, хүүхэд	Сумдын хэрэгжүүлэгч баг, Байгаль орчны салбар-БОГ, ИБДЦГЗ, БЦНОСГЗ, СДОА, Сумдын ЗДТГ, БОГ мэргэжилтэн

Зорилт 3. “Эрүүл мэнд, эзрэг харилцааг эрхэмлэгч сум” зорилтын хүрээнд

1	2	3	4	5	6	7	8
11	3.1. “Эрүүл мэндийг эрхэмлэгч сүм” цэнгээнт бүжиг, дасгал хөдөлгөөн хийж хэвших	Тухайн сум	-Нийт хүн амын хамрагдсан иргэдийн хувь -Зохион байгуулсан ажлын тоо -Цэнгээнт бүжиг, дасгал хөдөлгөөний уриалга, бичлэг байршуулсан тоо	a. Сум тус бүр нийтийн цэнгээнт бүжиг, ажлын байрны дасгал хөдөлгөөн сурах үйл ажиллагаанд нэгдэж, нийт хүн амынхаа 5-аас багагүй хувийг хамруулан, дадал хэвшил болгох ажлыг 2-оос доошгүй удаа зохион байгуулсан байна. б. Цэнгээнт бүжиг болон дасгал хөдөлгөөнд нэгдэхийг уриалсан уриалга, явцын бичлэгийг сүм болон байгууллагын пэйж хуудас, группдэд 8-аас багагүй удаа нийтэлнэ.	04-11 сар	Суралцагч байгууллага, гэр бүл, иргэн	ЭМГ, БТСГ Сумдын ЗДТГ, НЭМА хариуцсан мэргэжилтэн, БТ-ийн арга зүйч, төрийн байгууллагууд
12	3.2. “Хөгжлийг эрхэмлэгч сүм” хувь хүний хөгжлийн багц сургалтад хамрагдах	Тухайн сум, байгууллагын тоо	-Сургалтын тоо - Сургалтад хамрагдсан байгууллага, албан хаагч, гэр бүл, иргэний тоо - Сертификаттай болсон оролцогчдын хувь - Өрхийн төсвийн дэвтэр хөтөлж хэвшсэн иргэдийн тоо	a. 5-аас багагүй сургалтыг зохион байгуулан 3000-н албан хаагч, 250 гэр бүл, 1200 иргэн хамрагдана. б. Зангия академийн цахим сургалтад албан хаагчид, гэр бүл, иргэд, суралцагчид өөрсдийн хэрэгцээнд суурilan 3 багц сэдэв сонгон судалж нийт оролцогчдын 95-аас багагүй хувь хамрагдан сертификаттай болсон байна. в. Өрхийн төсвийн дэвтрийн загварыг гарган өгч 3000-аас багагүй иргэдийг хөтөлж хэвшүүлэхэд чиглүүлэг өгнө.	04-11 сар	Суралцагч байгууллага, гэр бүл, иргэн,	Сумдын НТСН-ийн менежер, багш, НТСТ, Зангия академи
13	3.3 “Суралцахуйн баяр- Суралцахуйг эрхэмлэгч сүм” арга хэмжээг зохион байгуулах	Тухайн сум	-Хамруулсан иргэдийн тоо -Бусдаас суралцсан иргэдийн тоо	20-оос багагүй иргэнийг хамруулна. Нийт хүн амын 5-аас багагүй иргэнд хүрч үйлчилж, суралцахуйг дэмжсэн байна.	III улирал	НТСТ, сумдын хэрэгжүүлэгч баг	Аймгийн ЗДТГ, НТСТ, сумдын ЗДТГ

1	2	3	4	5	6	7	8
14	3.4. “Эрүүл мэндээ хамгаалья” багц сургалтад хамрагдах	Тухайн сум, байгууллага	-Нийт оролцогчдын сургалтад хамрагдсан хувь	Сум тус бүр 4 чиглэлийн хүрээн дэх багц сургалтуудад байгууллагын албан хаагчдын 70-аас доошгүй хувь, зорилтот гэр бүлийн 70-аас доошгүй хувь, зорилтот иргэний 70-аас доошгүй хувь, зорилтот хүүхдийн 70-аас доошгүй хувийг тус бүр хамруулсан байна.	04-11 сар	Суралцагч байгууллага, гэр бүл, иргэн, хүүхэд	НТСТ, БГ, ЭМГ, ХХААГ, Сумдын НТСН-ийн менежер, багш,
15	3.5. “Эрүүл иргэн- Зөв монгол” нэлөөллийн ажил зохион байгуулах	Тухайн сум, байгууллага	- Нэлөөллийн ажлын тоо - Хамрагдсан иргэдийн хувь - Ажлын тайлан	- 38-аас багагүй нэлөөллийн ажлаар дамжуулж нийт хүн амын 20-иос доошгүй хувийг хамруулан тайланг шалгуурын дагуу бичиж ирүүлнэ.	04-11 сар	Сумдын хэрэгжүүлэгч баг	Сумдын ЗДТГ, ЕБС, СӨБ, Соёлын төв, Эрүүл мэндийн төв
<b>Зорилт 4. “Өв соёлоо эрхэмлэгч сум” зорилтын хүрээнд</b>							
16	4.1. “Монгол бичгийн үндэсний хөтөлбөр- III”-ын хэрэгжилтийг хангах	Тухайн сум, байгууллага	-Хэрэгжүүлсэн байгууллагын тоо - Чадваржсан албан хаагчдын тоо	- Байгууллага бүр үндэсний хөтөлбөрийн ажил тус бүрийг 50-иас доошгүй хувьтай хэрэгжүүлсэн байх. - Албан хаагчдын мэдлэгт суурилсан үндэсний бичгийн сургалт авах; /Анхан, дунд, цахим бичвэр/ - Албан хэргийг хос бичгээр хөтлөх; - Нэрийн хуудсыг хос бичгээр үйлдэж, хэрэглэх; - Гадна, дотор хаягжилтыг хос бичгээр үйлдэх; - Албан хэрэгцээний баримт бичгийн хаягийг хос бичгээр хөтлөх; - Байгууллага бүр гарын авлага, постер мэдээллээ хос бичгээр үйлдэж, түгээх; - Цахим орчинд мэдээллээ хос бичгээр хөтлөх;	04-11 сар	Суралцагч байгууллага	НТСТ, СУАЖЗХГ, ХБҮЗ-ийн БХР аймаг дахь СЗ Сумдын ХБСЗ, НТСН, Соёлын төв, Монгол хэл бичгийн багш нар

1	2	3	4	5	6	7	8
				<ul style="list-style-type: none"> <li>- Хүмүүн бичиг сонин, Тод мэр номыг захиалж, хэрэглээ болгох;</li> <li>- Аж ахуй нэгж байгууллагын бараа бүтээгдэхүүний шошго, танилцуулгыг хос бичгээр хөтлөх;</li> <li>-Бусад- Шинээр санаачлан хэрэгжүүлж буй үлгэр жишээ ажлын туршлагаа тайланд тусган ирүүлэх;</li> <li>-Хэрэгжилтийн мэдээ авах шалгуурыг файлаар хүргэнэ.</li> </ul>			
17	4.2. МУ-ЫН Ерөнхийлөгчийн 2017 оны 25 дугаар зарлигаар батлагдсан “Эх хэлний өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх	Тухайн сум, байгууллага	<ul style="list-style-type: none"> <li>-Хэрэгжүүлсэн байгууллагын тоо</li> <li>-Албан хаагчдын тоо</li> <li>-Уралдаанд оролцсон албан хаагчдын тоо</li> <li>- Оролцсон байгууллагын тоо,</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Байгууллага тус бүр нөлөөллийн ажил зохион байгуулж, албан хаагчдын 70-аас доошгүй хувийг хамруулна. Тухайлбал: Байгууллага бүр сургалт хөгжлийн цагаараа “Эх хэлний эзэд” 30 минутын уншлага, хэлэлцүүлгийг зохион байгуулах г.м/ - “Эх хэл-Тусгаар тогтнол” хичээнгүй бичлэгийн уралдаан, “Үндэсний бичгийн олимпиад”-ыг тус бүр зохион байгуулж 100-аас багагүй байгууллагын 2000-аас багагүй албан хаагчид оролцно.</li> </ul>	09-11 сар		
18			<ul style="list-style-type: none"> <li>- Хамрагдсан ангийн тоо</li> <li>-Оролцсон сурагчдын тоо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сонгогдсон анги хамт олон тухайн ангийн уран зохиолын агуулгын хүрээнд шүлэг, яруу найргийг судалж, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх цахим контент/бичлэг бүхий нөлөөллийн ажлыг зохион байгуулна. Үүнд: а. 4-р анги: Уламжлалт мэндлэх, хүндлэх ёсыг танин мэдэж, түгээн дэлгэрүүлэх б. 6-р анги: Зүйр цэцэн үгийн сургамжит утгыг танин мэдэж, түгээн</li> </ul>	09 сар	Суралцагч хүүхэд	НТСН, Соёлын төв, , монгол хэл бичгийн багш нар

1	2	3	4	5	6	7	8
				дэлгэрүүлэх ажлын хүрээнд 56 ангийн 1400-н сурагчид хамрагдана. - Удирдамж, чиглэл хургэгдэнэ.			
19	4.3. МУ-ын Ерөнхийлөг -чийн 2003 оны 105 дугаар зарлигаар батлагдсан “Үндэсний бичиг үсгийн баярын өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх	Тухайн байгууллага	- Нийт албан хаагчийн тоо -Уралдаанд оролцсон гэр бүл, иргэний тоо - Хамрагдсан ангийн тоо -Суралцаагчдын тоо	a. Төрийн байгууллагуудын дунд үндэсний бичгийн “Массын олимпиад”-ыг зохион байгуулж 300-н албан хаагчдыг хамруулна. б. Оролцогч гэр бүл, иргэдийн дунд “Эх хэл – Тусгаар тогтолц” хичээнгүй бичгийн уралдааныг зохион байгуулж 250-иас баагүй оролцогчдыг хамруулна. в. Сонгогдсон анги хамт олон тухайн ангийн уран зохиолын агуулгын хүрээнд шүлэг, яруу найргийг судалж, өв соёлоо түгээн дэлгэрүүлэх цахим контент/бичлэг бүхий нэлэөллийн ажлыг зохион байгуулна. Үүнд: - <b>8-р анги:</b> С.Дуламын “Хүмүүн бичиг”, О.Дашбалбарын “Өвөг дээдсээсээ бид эх орноо хүлээж авсан үр хойчдоо хүлээлгэж өгнө” шүлгийг судалж, түгээн дэлгэрүүлэх - <b>10-р анги:</b> Монголын нууц товчоон”-г бүтээлчээр уншиж судлан, түгээн дэлгэрүүлж нийт 56 ангийн 1400 сурагчдыг хамруулна. - Тус бүрийн удирдамж, чиглэл хургэгдэнэ.	4-5,11 сар	Суралцаагч байгууллага, гэр бүл, иргэн, хүүхэд	НТСТ, ХБҮЗ-ийн БХР дахь СЗСумдын ХБСЗ, НТСН, монгол хэл бичгийн багш нар
20	4.4 “Өв соёлыг эрхэмлэгч гэр бүл”	Тухайн гэр бүл	-Хамрагдсан гэр бүлийн тоо - Нэлэөллийн ажлын тоо	- Соёлын биет бус өвийн төрлүүд/үлгэр домог, хөөмий, магтаал, ереөл, биелгээ, тоглоом наадгай, угийн бичиг...гм/-ээс сонгон суралцах ба 15-аас доошгүй	4-11 сар	Суралцаагч гэр бүл	НТСН, Соёлын төв

1	2	3	4	5	6	7	8
				нөлөөллийн ажлаар 500-аас багагүй гэр бүлд нөлөөлөх, өв соёлоо сурталчлах ажил арга хэмжээг зохион байгуулж цахим орчинд түгээн дэлгэрүүлнэ. - Удирдамж, чиглэл хүргэгдэнэ.			
21	4.5. “Соёлын биет бус өвийг дэлгэрүүлэгч” нөлөөллийн ажил зохион байгуулах	Тухайн сум, байгууллага	- Нөлөөллийн ажлын тоо -Хамрагдсан хүн амын хувь -Алдаршуулсан иргэдийн тоо	- Сум бүр орон нутгийнхаа онцлох өв соёлыг сурталчлах, дэлгэрүүлэх нөлөөллийн ажлыг анги хамт олон, иргэд, гэр бүл, байгууллагын хүрээнд 15-аас доошгүй удаа зохион байгуулж нийт хүн амын 20-иос доошгүй хувьд нөлөөлсөн байна. -Соёлын биет бус өвийг өвлөн дэлгэрүүлэгч 5-н иргэнийг цахим орчинд сурталчлан алдаршуулна. - Удирдамж, чиглэл хүргэгдэнэ.	04-11 сар	Хэрэгжүүлэг ч баг	НТСТ, СУАЖЗХГНТС Н, Соёлын төв

ХЯНАСАН:

НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН  
ЗАХИРАЛ

Д.АМГАЛАН

ТӨЛӨВЛӨГӨӨГ НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН:  
НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН ТӨВИЙН  
СУРГАЛТЫН МЕНЕЖЕР

Т.БАТЖАРГАЛ

НАСАН ТУРШИЙН СУРАЛЦАХУЙН  
ТӨВИЙН БИЧИГ ҮСГИЙН  
БОЛОВСРОЛЫН БАГШ

Г.ДОЛГОРСҮРЭН

**Иргэдийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх чиглэлийн хүрээнд судлуулах хуулийн жагсаалт:**

	Хуулийн нэр томьёо	Хугацаа	Хариуцах байгууллага
1	2	3	6

**Албан хаагчдын хүрээнд**

1	Үндсэн хууль	04-11 сар	Монгол нотариатчдын танхимын БХР аймаг дахь салбар, Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, холбогдох мэргэжилтнүүд
2	Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хууль		
3	Захиргааны ерөнхий хууль		
4	Төрийн албаны тухай хууль		
5	Гэр бүлийн тухай хууль		
6	Хөдөлмөрийн тухай хууль		
7	Авиалгын эсрэг хууль		

**Гэр бүл, Иргэдийн хүрээнд**

1	Зөрчлийн тухай хууль	04-11 сард	Аймгийн ЗДТГ-ын Хууль зүйн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, холбогдох мэргэжилтнүүд
2	Гэр бүлийн тухай хууль, гэрлэлтээ батлуулахын ач холбогдол		
3	Нийгмийн даатгал, тэтгэвэр тэтгэмжийн тухай хууль		
4	Хүүхэд хамгааллын тухай хууль		

Аймгийн Засаг дахьны 103 дугаар  
сарын 10 -ны өдрийн 1 дугаар захирамжийн  
дүгээр хэвсэлт



**"СУРАЛЦАГЧ АЙМАГ" ТӨСӨЛТ АЖЛЫН  
САНХҮҮГИЙН ЗАРЦУУЛАЛТ**

№	Зардлын нэр төрөл	Тоо/ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5
1	"Суралцагч сум" 1-р байр	1	4.000.000	4.000.000
2	"Суралцагч сум" 2-р байр	1	3.000.000	3.000.000
3	"Суралцагч сум" 3-р байр	1	2.000.000	2.000.000
4	Өргөмжлэл	16	62500	1.000.000
			<b>Нийт</b>	<b>10.000.000</b>

\_\_\_\_\_ оо \_\_\_\_\_